ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ДГА-2023/176/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn

Сайншанд сум

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991
Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn
2023.02.24 № 1-6/232

танай ________ -ны № ________ -т

ХАЛАМЖИЙН САНГИЙН ДАРГА
Д.ЦЭНДМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Халамжийн сангийн /Улсын төсвөөс санхүүжих/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Халамжийн сангийн /Улсын төсвөөс санхүүжих/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаж, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 143.3 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт төсөв, хөрөнгө зарцуулах 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 73.5 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29.9 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 29.8 сая төгрөгийн 9 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн

дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээ нь халамжийн нэгдсэн систем "ehalamj.mn"-д шилжиж байгаатай холбоотойгоор халамжийн сангийн орлогыг төв дансанд нэгдсэн журмаар төвлөрүүлж, зарцуулалтыг багцын гүйлгээгээр хийж, 2022 оны 02 дугаар сарын 1-ний өдрөөс арилжааны банкны дансуудыг хааж, улсын төсвийн санхүүжилтийг зогсоосон байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **I** | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | **0.00** | **0.00** |
| **3101** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | **0.00** | **0.00** |
| 3.1.4.1 | Банкинд байгаа бэлэн мөнгө/ОНТөсөв/ | **0.00** | **0.00** |
| | АВЛАГА | **0.00** | **0.00** |
| **33** | **Орон нутгийн төсвийн авлага** | **0.00** | **0.00** |
| 33 | Байгууллагаас авах авлага | **0.00** | **0.00** |
| 33 | Хувь хүмүүсээс авах авлага | **0.00** | **0.00** |
| | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **0.00** | **0.00** |
| | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | **0.00** | **0.00** |
| | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **0.00** | **0.00** |
| | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **413** | **Өглөг** | **0.00** | **0.00** |
| 4101 | Хэлтэс хоорондын тооцоо | **0.00** | **0.00** |
| 410101 | Байгууллага хоорондын тооцоо УТ | **0.00** | **0.00** |
| 410102 | Байгууллага хоорондын тооцоо | **0.00** | **0.00** |
| 410301 | Хувь хүнд өгөх улсын төсвийн өглөг | **0.00** | **0.00** |
| 410302 | Хувь хүнд өгөх ОНТөсвийн өглөг | **0.00** | **0.00** |
| 410302 | Байгууллагад өгөх ОНТөсвийн өглөг | **0.00** | **0.00** |
| 4 | Урьдчилж орсон орлого | **0.00** | **0.00** |
| 41040101 | Урьдчилж орсон орлого Улсын төсөв | **0.00** | **0.00** |
| 41040102 | Урьдчилж орсон орлого Орон нутаг | **0.00** | **0.00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **0.00** | **0.00** |
| 41 | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **0.00** | **0.00** |
| 41 | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **0.00** | **0.00** |
| 510301 | Өмнөх үеийн үр дүн | **0.00** | **0.00** |
| 5103010002 | Өмнөх үеийн үр дүн орон нутаг | **0.00** | **0.00** |
| 510302 | Тайлант үеийн үр дүн | **0.00** | **0.00** |
| 5103020002 | Тайлант үеийн үр дүн орон нутаг | **0.00** | **0.00** |
| **0** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН** | **0.00** | **0.00** |
| **0** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **0.00** | **0.00** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Мөр | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| 1303 | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3] | 3,673,572,800.00 | 73,536,000.00 |
| 130301 | Улсын төсвийн санхүүжилтын орлого | 3,673,572,800.00 | 73,536,000.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4] | 3,673,572,800.00 | 73,536,000.00 |
| 2603 | Төсөвт төвлөрүүлэх [16]+[17] | 80,728,169.00 | 4,639,320.00 |
| 260301 | Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв | 80,728,169.00 | 4,639,320.00 |
| 2701+2702 | НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [40]-р мөр | 3,591,070,131.00 | 68,896,680.00 |
| 2701010101 | Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт | 971,518,853.00 | 0 |
| 2701010102 | Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт | 986,719,941.00 | 0 |
| 2701010103 | Амжиргаа дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт | 846,515,790.00 | 0 |
| 2701010900 | Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт | 214,424,300.00 | 48,444,100.00 |
| 2701010105 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт | 207,411,595.00 | 3,956,580.00 |
| 2701010106 | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт | 350,797,816.00 | 16,496,000.00 |
| 2701010108 | Амжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал | 13,681,836.00 | 0 |
| . | Банкны шимтгэл УТ [42]+[43]+[44]..+[56] | 1,774,500.00 | 0 |
| 2702010311 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл | 1,774,500.00 | 0 |
| . | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40] | 3,673,572,800.00 | 73,536,000.00 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Д/д | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1303 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3] | 3,673,572,800.00 | 73,536,000.00 |
| 130301 | Улсын төсвийн санхүүжилтын орлого | 3,673,572,800.00 | 73,536,000.00 |
| 1401 | Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]+[9]+[10] | 12,245,650.00 | 0 |
| 1401013 | Улсын төсвийн буцаасан орлого | 12,245,650.00 | 0 |
| . | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ [1]+[4] | 3,685,818,450.00 | 73,536,000.00 |
| 2701+2702 | НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [18]+...+[78] | 3,603,315,781.00 | 68,896,680.00 |
| 2701021100 | Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт | 973,035,580.00 | 0 |
| 2701021200 | Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт | 987,808,580.00 | 0 |
| 2701010103 | Амжиргаа дэмжих мөнгөн тэтгэжийн зарцуулалт | 847,276,290.00 | 0 |
| 2701021500 | Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт | 214,424,300.00 | 48,444,100.00 |
| 2701021604 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт | 207,873,195.00 | 3,956,580.00 |
| 2701024000 | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт | 359,216,000.00 | 16,496,000.00 |
| 2702020308 | Амжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал | 13,681,836.00 | 0 |
| . | Банкны шимтгэл [40]+[44] | 1,774,500.00 | 0 |
| . | Банкны шимтгэл УТ [41]+[42]+[43] | 1,774,500.00 | 0 |
| 2702010311 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл | 1,774,500.00 | 0 |
| 2603 | Төсөвт төвлөрүүлэх [53]+[55] | 80,728,169.00 | 4,639,320.00 |
| 260301 | Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв | 80,728,169.00 | 4,639,320.00 |
| . | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН [12]+[17]+[39]+[49]+[52]+[61]-[62]+[63]-[64] | 3,685,818,450.00 | 73,536,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | - | - |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 0.00 | 0.00 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Мөр | Сангийн орлого | Төлөвлөгөө | Тайлант оны гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 2 | Сангийн үйл ажиллагааны зардал | 1,050,236,000.00 | 68,896,680.00 | 981,339,320.00 |
| 10 | Банкны шимтгэл | 5,400,000.00 | 0 | 5,400,000.00 |
| 13 | Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал | 348,156,000.00 | 48,444,100.00 | 299,711,900.00 |
| 15 | Амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс | 22,680,000.00 | 0 | 22,680,000.00 |
| 17 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт | 216,000,000.00 | 3,956,580.00 | 212,043,420.00 |
| 18 | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт | 458,000,000.00 | 16,496,000.00 | 441,504,000.00 |
| 22 | УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ | 1,050,236,000.00 | 68,896,680.00 | 981,339,320.00 |
| 23 | Тохируулгын дүн | 0 | 68,896,680.00 | -68,896,680.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад 1 алдааг залрууллаа.

### 3.1 Залруулсан алдаа:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлан батлагдсан төлөвлөгөөгүй, үр дүнгийн тайлан зэрэгцүүлэгдээгүй байдлаар дутуу ирүүлснийг залруулсан.

Аудитаар нийт 1 зөрчил[2] илэрснээс 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

### 3.2 Албан шаардлага

1. **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 143.3 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт төсөв, хөрөнгө зарцуулах 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 73.5 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29.9 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 29.8 сая төгрөгийн 9 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлан батлагдсан төлөвлөгөөгүй, үр дүнгийн тайлан зэрэгцүүлэгдээгүй байдлаар дутуу ирүүлсэн | 1 | | 1 | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **1** | | **1** | | | | **1** | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 143.3 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт төсөв, хөрөнгө зарцуулах 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 73.5 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29.9 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 29.8 сая төгрөгийн 9 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. | 1 | | - | - | 1 | - | | |
| Дүн | 1 | | - | - | 1 | - | | |